



САГСАЙ СУМЫН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

Баян-Өлгий аймаг дахь
Төрийн аудитын газар

Тэргүүлэх аудитор
М.Хуанган
Утас: 70422954
Цахим хаяг:

Аудитын менежер:
Х.Женисбек
Утас: 70422930
Цахим хаяг:

Аудитор: Х.Еркебулан
Утас: 70423073
Цахим хаяг: akon_erka@yahoo.com

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хаяг: Баян-Өлгий аймаг дахь
Төрийн аудитын газар

Байршил: Өлгий сум, 5-р баг,
Аймгийн ЗДТГазрын байр, 1-р
давхар

Цахим хуудас: www.bayan-ulgii.gov.mn

2018 оны 3 дугаар сар

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар
17. Зөвлөмж
18. Аудитын гэрчилгээ тохирох загварын талаарх дүгнэлт

Нэг. Аудит хийх хууль, эрх зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1 дэх заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2-т заасан аймаг дах Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны оны санхүүгийн нэгтгэсэн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитыг 2018 оны 3 дугаар сарын 16-нээс 3 дугаар сарын 25-ний хооронд хийхээр төлөвлөн аймаг дах Төрийн аудитын газрын аудитор Х.Еркебулан хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төрийн аудитын байгууллагад 2018 оны 03-р сарын 05-ны өдрийн №01/71-р албан бичгээр 3 дугаар сарын 06-нд ирүүлсэн.

Баян-Өлгий аймаг дах Төрийн аудитын газар аудитыг 2018 оны 3 дугаар сарын 18-наас 3 дугаар сарын 28-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 3 дугаар сарын 29 -нд Сагсай сумын Засаг даргад гардуулна.

Хоёр. Байгууллагын хууль, эрх зүйн орчин

Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн захирагч нь Монгол улсын Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн албаны тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Татварын багц хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Гурав. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь “Хөрөнгө оруулалтыг сумын хөгжилтэй уялдуулах замаар ард түмний санал, санаачилгад тулгуурлан хэрэгжүүлснээр нийгэм, эдийн засгийн хөгжлийг хурдасгаж аймгийн “Загвар сум” болно” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагаагаа эрхлэн гүйцэтгэж байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн удирдлага дор төсвийн шууд захирагчийг харьяалах эрх бүхий төсвийн төвлөрүүлэн захирагчтай байж болно”, 15.4-д “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 15.4.1-д “төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-д заасны дагуу гэж Сагсай сумын Засаг дарга нь төсвийн төвлөрүүлэн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. 2017 оны төсвийг орон нутгийн төсөв, тусгай зориулалтын шилжүүлэгийн төсвийн багцаас аймгийн төрийн сангаар дамжуулан Сагсай сумын төрийн сангаас олгосон байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Дөрөв. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 7-ийг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад тус сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг батлаагүй боловч Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан төсвийн байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх заавар аргачлал, нягтлан бодох бүртгэлийн бодлого, арга зүйг, Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ыг мөрдөж ажилласан байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа программын үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэлгүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан тэмдэглэл тодруулга, бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд санхүүгийн “Пластик”, “Аколоус” програм хангамж ашиглажээ.

Тав. Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед “бага” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Зургаа. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Аймгийн ТЭЗ-ийн орон нутгийн төсөв, тусгай зориулалтын шилжүүлэгийн төсвийн багцаас аймаг, сумын төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан байна.

6.1. Орлого, татаас санхүүжилтийн талаар:

6.1.1 Улсын төсвийн санхүүжилт

Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлангаар тайлант онд тусгай зориулалтын шилжүүлгээр нийтдээ 2360.3 сая төгрөгийн санхүүжилт, 7.1 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийг хүлээн авсан байна.

6.1.2 Орон нутгийн төсвийн санхүүжилт

Орон нутгийн захиргааны байгууллагууд аймгийн төсвөөс 302.5 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг хүлээн авч, орон нутгийн татварын орлогоос 34.1 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлэн санхүүжүүлсэн байна. Нэмэлт санхүүжилтээр 19.0 сая төгрөг хүлээн авчээ.

6.1.3 Үндсэн үйл ажиллагааны орлого

Сагсай сумын төсөвт байгууллагуудад үндсэн үйл ажиллагаанаас 1.07 сая төгрөгийн орлого оруулах төлөвлөгөө өгөгдсөнөөс 0.05 сая төгрөгийн орлого оруулж, 1.02 сая төгрөгөөр тасалдуулсан байна.

6.1.4 Орон нутгийн татварын орлого

Сагсай сумын ИТХ-аас сумын 2017 оны Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 28.8 сая төгрөгөөр баталжээ. Орлогын бүтцийг авч үзвэл нийт орлогын 56.3 хувийг ХАОАТатвараас, 43.7 хувийг бусад татварын орлогоос оруулахаар төлөвлөжээ.

Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал: /сая төгрөг/

Үзүүлэлт	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	хувь
Нийт орлогын дүн	28.8	34.1	5.3	118.5%
Татварын орлого	28.8	28.5	0.3	98.9%
ХАОАТатвар	16.2	14.3	-1.9	88.5%
Өмчийн татвар	2.8	1.1	-1.7	39.0%
Бусад татвар	9.8	7.5	-2.3	77.1%
Татварын бус орлого		5.6	5.6	
Б.ХӨРӨНГИЙН ОРЛОГО				

Гүйцэтгэлээр Орон нутгийн орлогод нийтдээ 34.1 сая төгрөгийн орлого төвлөрүүлж төлөвлөгөөг 5.3 сая төгрөгөөр буюу 118.5 хувиар давуулан биелүүлжээ. Нийт орлогын 83.5 хувийг татварын орлогоос, 16.5 хувийг татварын бус орлогоос бүрдүүлжээ.

Орлогын нэр төрлөөр авч үзэхэд ХАОАТатвар 1.8 сая төгрөгөөр, бусад татвар 2.2 сая төгрөгөөр, өмчийн татвар 1.7 сая төгрөгөөр тасарчээ. Хүүгийн орлогоос татварын бус орлогод 5.6 сая төгрөгийн орлогыг төлөвлөснөөс илүү оруулсан нь төлөвлөгөө нийт дүнгээр давж биелэгдэхэд гол нөлөө үзүүлжээ.

Орон нутгийн ерөнхий орлогын 910 тоот дансанд оны эхэнд 10.0 төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба Орон нутгийн орлогын 995 тоот дансаар 34.1 сая төгрөгийн татварын орлого оруулж, оны эцэст орон нутгийн төсвийн ерөнхий орлогын 910 тоот дансанд 5.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Сумын төсөвт байгууллагуудаас аймгийн төрийн сан дахь цалин хөлсний татварын орлогын 901 тоот дансанд нийтдээ 135.9 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна.

6.1.5 Бусад орлого

Тайланд онд Орон нутгийн хөгжлийн санд 26.8 сая төгрөгийн санхүүжилт авч, Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөс 17.3 сая төгрөгийн, Эргэлтийн эмийн санд 5.5 сая төгрөгийн орлого оруулсан байна.

6.2. Төсвийн зарлага санхүүжилтийн талаар:

6.2.1 Төсвийн гүйцэтгэлийн талаар

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой төсөвт байгууллагуудын хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2017 оны урсгал зардалд нийтдээ 2810.6 сая төгрөгийн төсөв батлагдсаны 2360.3 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээр, 331,3 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 51,1 сая төгрөгийг ОНХСангаас, 57.4 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоос, 10,5 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр тусгажээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээр 2360.3 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 331,3 сая төгрөгийн, ОНХСангаас 51,1 сая төгрөгийн санхүүжилтийг авч, үйл ажиллагааны орлогоос 27,9 сая төгрөг, урьд оны үлдэгдлээс 10.5 сая төгрөг бүрдүүлж бүгд дүнгээр 2777,0 сая төгрөгийн зарлага санхүүжилтээр ажиллаж,

батлагдсан төсвөөс нийт дүнгээр 51,8 сая төгрөгөөр бага зарлага гаргажээ.Энэ нь Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөс төлөвлөсөн орлого бүрдээгүй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.
/сая төгрөг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү /мөнгөн дүнгээр/	Зөрүү /Хувиар/
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	2824.0	2791.6	32.4	98.8%
1.1	Урсгал зардал	2824.0	2791.6	32.4	98.8%
2	Зардлыг сахуужуулах эх үүсвэр	2824.0	2791.6	32.4	98.8%
2.1	Улсын төсвөөс санхүүжих /Тусгай зориулалтын шилжүүлэг/	2306.3	2367.3		
2.2	Орон нутгийн төсвөөс	410.4	393.5	16.9	
2.3	Орон нутгийн хөгжлийн сангаас	26.8	26.8		
2.4	СХСангаас	19.5	4.0	15.5	20.4%

Төсвийн гүйцэтгэлийг байгууллага бүрээр харуулбал: /сая төгрөг/

Төсөвт байгууллагуудын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Сумын ИТХурал	46.2	46.2	0	100.0%
Сумын ЗДТГазар	364.2	347.3	16.9	95.4%
Бүрэн дунд сургууль	1442.9	1442.9	0	100.0%
Эрүүл мэндийн төв	375.9	375.9	0	100.0%
Хүүхдийн цэцэрлэг	334.9	334.9	0	100.0%
Соёлын төв	61.6	61.6	0	100.0%
Даян бага сургууль	152.0	152.0	0	100.0%
СХСан	19.5	4.0	15.5	20.5%
ОНХСан	26.8	26.8	0	100.0%
Бүгд	2824.0	2791.6	32.4	98.8%

Сумын төсөвт байгууллагууд батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.

/сая төгрөг/

Үзүүлэлт	Тайлант оны		
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2824.0	2791.6	32.4
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1710.8	1711.5	-0.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	181.3	181.3	0.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	198.0	194.0	4.0

Хангамж, бараа материалын зардал	49.5	50.4	-0.9
Нормативт зардал	224.0	223.0	1.0
Эд хогшил, урсгал засварын зардал	11.2	13.1	-1.9
Томилолт, зочны зардал	5.3	5.3	0.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	36.0	36.2	-0.2
Бараа үйлчилгээний бусад зардал	75.9	25.4	50.5
Бусад урсгал шилжүүлэг	332.0	351.4	-19.4

6.2.2 Нэмэлт санхүүжилтийн зарцуулалт

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн дансаар нийтдээ 26.1 сая төгрөгийн орлого хүлээн авч урсгал зардалд 26.1 сая төгрөгийг зарцуулсан байна. Дээрх зардлыг санхүүжүүлсэн эх үүсвэрийг ангилал тус бүрээр нэмэлт төсвийн тайлангаар баримтжуулан баталгаажуулав.

6.2.3 Сангуудын зарцуулалт

Сагсай сумын ОНХСан нь тайлант онд 51.1 сая төгрөгийн санхүүжилт авч, 26.7 сая төгрөгийг сумын ИТХурлаас батлагдсан төсөл арга хэмжээнд зарцуулж, 24.4 сая төгрөгийг МЭҮАХЗардлын санхүүжилтэнд олгож, оны эцэст 0.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Сум хөгжүүлэх сангийн харилцах данс оны эхэнд 2.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй, тайлант онд эргэн төлөлтөөс 17.3 сая төгрөгийн орлогыг оруулж, тайлант онд 3.9 сая төгрөгний зээл олгож, оны эцэст 15.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Эргэлтийн эмийн сан харилцах данс оны эхэнд 0.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй, тайлант онд 5.5 сая төгрөгийн орлого оруулж, 4.8 сая төгрөгийг зарцуулж оны эцэст 1.0 үлдэгдэлтэй гарсан байна.

БОНСТСанг тайлант оны эхэнд 3.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй, тайлант онд 8.7 сая төгрөгийн орлого оруулж, 3.8 сая төгрөгийг зарцуулж оны эцэст 7.9 үлдэгдэлтэй гарсан байна.

6.3. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтийн талаарх тайлбар, тодруулга

6.3.1 Мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

/сая төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт бууралт
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	15.5	32.4	16.9
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	0.00	0.00	0.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	15.5	32.4	16.9
3121	Төгрөг	15.5	32.4	16.9

31211	Төрийн сангийн харилцах	15.2	31.4	16.2
31213	Арилжааны банк дахь харилцах	0.3	1.0	0.7

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар оны эцэст нийтдээ 32.4 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарчээ. Мөнгөн хөрөнгийн бүтцийг авч үзвэл нийт үлдэгдэл мөнгөний 0.9 сая төгрөг нь арилжааны банкин дахь, 31.4 сая төгрөг нь төрийн сан дахь харилцах дансны үлдэгдэл байна.

Арилжаны банкинд байгаа 0.9 сая төгрөг нь Эргэлийн эмийн сангийн дансны үлдэгдэл байна.

6.3.2 Авлагын бүртгэл, тайлагнал

/сая төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт бууралт
33	АВЛАГА	308.9	256.9	-52.0
335	Бусад авлага			
33300	Татаас, санхүүжилтийн авлага	11.9	13.8	-1.9
3351	Байгууллагаас авах авлага			
3352	Хувь хүмүүсээс авах авлага			
336	Зээлийн авлага	297.0	243.1	-53.9
3361	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	297.0	243.1	-53.9
33612	Хувь хүмүүст олгосон зээл	297.0	243.1	-53.9

Санхүүгийн тайлан дахь авлагын үлдэгдэл өмнөх оноос 52.0 сая төгрөгөөр буурсан дүнтэй байна. Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлагыг тооцоо нийлж, зээлдэгч нэг бүрээр гарын үсэг зуруулж үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

6.3.3 Бараа материалын бүртгэл, тайлагнал

/сая төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт бууралт
35	БАРАА МАТЕРИАЛ	220.7	216.8	-3.9
351	Түүхий эд материал	12.3	9.2	-3.1
354	Хангамжийн материал	208.4	207.6	-0.8

Бараа материалын үлдэгдэл оны эхнээс 3.9 сая төгрөгөөр буурсан байна. Бараа материалын бүтцийг авч үзвэл 4.2 хувь нь түүхий эд материал, 95.8 хувь нь хангамжийн материал байна. Тайлант онд нийтдээ 9.1 сая төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

6.3.4 Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

/сая төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт бууралт
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4835.7	4603.1	232.6
391	Газар			0.00
392	Биет хөрөнгө	4835.4	4602.8	232.6
393	Биет бус хөрөнгө	0.3	0.3	0

Үндсэн хөрөнгө оны эхнээс 232.6 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд 7.1 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авч, 48.3 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авчээ. Төсөвт байгууллагууд нийтдээ 48.3 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авснаас Бүрэн дунд сургууль 38.9 сая төгрөгийн, ЗДТГазар 2.5 сая төгрөг ЭМТөвөөс 0.9 сая төгрөг, Хүүхдийн цэцэрлэг 6.0 хөрөнгийг хөрөнгө оруулалтаар хүлээн авсан байна.

Тайлант онд үндсэн хөрөнгөнд 288.1 сая төгрөгийн элэгдэл тооцож, данснаас хассан үндсэн хөрөнгийн 228.1 сая төгрөгний элэгдэлийг данснаас хасалт хийсэн байна.

6.3.5 Өр төлбөрийн бүртгэл, тайлагнал

/сая төгрөг/

4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	45.5	87.2	41.7
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	45.5	87.2	41.7
413	Өглөг	45.5	87.2	41.7
4136	Бусад өглөг	45.5	87.2	41.7
41361	Байгууллагад төлөх өглөг	45.5		45.5
41362	Хувь хүмүүст төлөх өглөг		87.2	-87.2

Оны эцэст ЗДТГазар 11.3 сая төгрөгийн, ИТХурал 0.5 сая төгрөг төгрөгийн,, Ахлах сургууль 46.6 сая төгрөг төгрөгийн, Хүүхдийн цэцэрлэг 1.0 сая төгрөг төгрөгийн, Даян бага сургууль 0.6 сая төгрөг төгрөгийн, Соёлын төв 0.2 сая төгрөг төгрөгийн, Хүн эмнэлэг 27.0 сая төгрөгийн нийтдээ 87.2 сая төгрөгийн өглөгтэй гарчээ.

6.3.6 Цэвэр хөрөнгө/өмчийн талаар

Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар цэвэр хөрөнгө өмчийн нийт дүн 5109.3 сая төгрөг буюу ЗГОКапитал 3195.9 сая төгрөг, дахин үнэлгээний нэмэгдэл 1554.9 сая төгрөг, хуримтлагдсан үр дүн 271.2 сая төгрөг байна. Тайлант онд -290.6 сая төгрөгийн үр дүнтэй ажиллаж, хуримтлагдсан үр дүн 1554.9 сая төгрөг болж өссөн байна.

Долоо. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангаж ажиллах зорилгоор shilendans.gov.mn цахим хуудсанд 2017 оны мэдээлэлээ бүрэн байршуулжээ.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд 2017 онд хийсэн нийцлийн аудитаар Сагсай сумын төсөвт байгууллагуудад Шилэн дансны тухай хуулийн 6.4.5 дахь заалтыг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгуулах албан шаардлага өгсөн ба 2017.12.21 №03/365 тоотын дагуу 1945.6 сая төгрөгний зөрчлийн биелэлтийг ирүүлсэн байна.

2017 оны 10-12 дугаар саруудын шилэн дансны мэдээллийг аудиторын зүгээс шалгаж Shilen dans-Sagsai sumiin TTZ файлаар баримтжуулж, тайлантай хамт ажлын талбарт хавсаргав.

Найм. Аудитын дүнгийн талаар

8.1. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 6 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 5 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

8.2. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар

Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний Орон нутгийн орлогын бүртгэл, тайлагнал, санхүүжилтийн эх үүсвэр, гүйцэтгэл, төсөвт байгууллага, сангуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг нэгтгэх, тулган баталгаажуулах зэргээр ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

8.3. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар материаллаг хэмжээний алдаа зөрчил илрээгүй. Материаллаг бус дараах асуудал байна.Үүнд:

1. Сагсай сумын нэгдсэн тайлангаар 2017 оны батлагдсан төсөвт орон тооны хязгаарыг 216.5 хүнээр тогтоосон 240.5 орон тоо ажиллуулж, орон тоог 24 хүнээр хэтрүүлэн ажиллуулсан байна.Үүнд БДСургуульд багш 10, ЭМТөвд сувилагч 3, асрагч 3, угаагч 1, эмийн санч 1, гэрээт 1, ЗДТГазарт 1 үйлчилүүлэгч,1 гэрээт ажилтан, Даян бага сургуульд багш 1, үйлчилүүлэгч 1, гэрээт 1, хүнээр илүү ажилуулжээ.Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 16 дугаар зүйлийн 16.5.3-т “Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2-т “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгдсэн тайлангаар Засаг даргад зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

2. Сум хөгжүүлэх сангийн зээлийн үлдэгдэлийг 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд зөрүүтэй нэгтгэснийг холбогдох санхүүгийн баримтыг үндэслэн дахин тооцоо хийж, тулган шалгаж, 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайлангаар 22869.1 мянган төгрөгийн авлагыг бууруулж залруулсан байна.

Шийдвэрлэсэн нь: СХСангийн зээлийн авлагыг цаашид тулган баталгаажуулж, санхүүгийн тайланд тусгаж байхыг зөвлөв.

8.4. Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Аудитын явцад залруулагдаагүй алдаа гараагүй болно.

8.5. Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

8.6. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

8.7. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй.

8.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хариуыг нь хугацаанд нь өгсөн байна.

8.9. Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар

Сагсай сумын Сумын ИТХурал, Соёлын төвийн санхүүгийн тайланд итгэл үзүүлж, Бүрэн дунд сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайлан, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд бие даасан дүгнэлт гаргалаа.

Сумын Засаг даргын тамгын газар, Даян бага сургууль, ОНХСан, Сум хөгжүүлэх сан, Эргэлтийн эмийн сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн дүгнэлтэд оруулав.

Аудитын үр дүнг хүснэгтээр нэгтгэн харуулбал:

Төсвийн шууд захирагчийн нэр	Алдаа, зөрчлийн дүн /сая. төг/	Аудиторын санал дүгнэлт бүгд	Үүнээс			
			Зөрчилгүй санал дүгнэлт	Хязгаарлалттай санал дүгнэлт	Сөрөг санал дүгнэлт	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
Бүрэн дунд сургууль	40.5	1		1		
Эрүүл мэндийн	27.0	1		1		
Хүүхдийн цэцэрлэг	0.0	1	1			
Даян бага сургууль	0.0					
Сумын ЗДТГазар	0.0					
ТТЗ-ийн СНТ	22.9	1	1			
Дүн	90.4	4	2	2		

8.10. Зөрчилгүй санал дүгнэлт

Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан ... хуудас хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

М.ХУАНГАН
Огноо:2018.03.29

Х.ЖЕНИСБЕК
Огноо:2018.03.29

Х.ЕРКЕБУЛАН
Огноо:2018.03.29